

НЭГ.СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд байгууллагын хөгжил,ажилтан, албан хаагчид хариуцлага, ёс зүй, үйлчилгээний чанарыг сайжруулах нь нэн тэргүүний асуудал болж байна.Энэхүү үйл ажиллагааг үр дүнд суурилсан, чанартай хэрэгжүүлэхэд мэргэжилтнүүдийн сэтгэл ханамж чухал юм.Эрүүл мэндийн ажилтан, албан хаагчдийн мэдлэг, мэргэжил, мэргэшил болон үр чадварын хөгжлийг дэмжих, эрүүл мэндийн салбарт шинэ технологи нэвтрүүлэх, шинэ мэдлэг, мэдээлэл үйлдвэрлэх замаар эрүүл мэндийн салбарын хөгжилд дэмжлэг үзүүлэх, өөрийн үйл ажиллагааг сайжруулах.Ажилтан, албан хаагчдийн мэдлэг үр чадварыг байнга дээшлүүлэх ажиллах нь чухал юм.

Зорилго: Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ажилтан, албан хаагчдийн сэтгэл ханамжид тулгуурлан байгууллагын үйл ажиллагааг сайжруулах.

Зорилт: Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ажилтан, албан хаагчдийн сэтгэл ханамжийг судлах

Үр дүн:Нотолгоонд үндэслэн байгууллагын хөгжил, зохион байгуулалт, үйлчилгээг сайжруулах арга замыг тодорхойлон, төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэх

ХОЁР.СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

2.1 Судалгааны арга зүй: Тоон судалгааны аргыг ашиглан нэгдсэн арга зүйд тулгуурлан, тусгайлан боловсруулсан асуумжаар судалгааг хийв.

2.2 Мэдээллийг боловсруулах:

- Тоон судалгаагаар цуглуулсан мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнг боловсруулахдаа SPSS болон Excel гэх мэт программуудыг ашиглана.
- Өгөгдөл оруулах, дүн шинжилгээ хийх программыг тусгайлан боловсруулж, үр дүнд статистикийн шинжилгээний аргыг ашиглан үр дүнгийн шинжилгээ хийж, тайлан бичнэ.
- Хариулт тус бүрийг 1-ээс 3 гэсэн оноогоор үнэлэн, хэмжигдэхүүний оноо 1-руу дөхөх тусам хамгийн өндөр сэтгэл ханамжтай байдал, 3-руу дөхөх тусам хамгийн бага сэтгэл ханамжтай байдлыг илэрхийлснээр үнэлнэ.

1 оноо = “сайн”, 2 оноо = “дунд”, 3 оноо = “муу”

Судалгааны хамрах хүрээ: Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 65 хүн (94,2%) ажилтан, албан хаагчдыг хамруулсан. Сэтгэл ханамжийн судалгааг 6 бүлэг, 40 асуултаар авч, 2014 оны 6 сарын 13-наас 6 сарын 30-ны хооронд хийсэн. энэхүү судалгааг бүлэг тус бүрээр үр дүнг гарган тайлан бичлээ.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН:

1.Дэмжлэгт удирдлага

Байгууллагын дэмжлэгт удирдлагын талаарх сэтгэл ханамж: Ажилтан, албан хаагчдын сэтгэл ханамжтай байдлыг хэмжигдэхүүн тус бүрээр авч үзэхэд:

- Судалгаанд хамрагдсан ажилтан, албан хаагчид хэлтсийн удирдлагын удирдах арга барил, манлайлах үр чадварт 73.4%, байгууллагын удирдлагын удирдах арга барил, манлайлах үр чадварт 61.7%, Шинэ санаа, санаачлагыг дэмжих, нэвтрүүлэх байдал, удирдлагадаа санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж, удирдлагадаа санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж, ажилтан, албан хаагчдийн эрүүл мэндийн хамгаалах үйл ажиллагаа зэрэгт тус бүр 63.6% байна.
- Судалгаанд хамрагдсан ажилтан, албан хаагчдийн шийдвэр гаралтанд хамт олны оролцоо, мөнгөн бус тусламж, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэлт, тасралтгүй суралцагч байгууллага байх тогтолцоонд 54.2 % байна.
- Судалгаанд хамрагдсан ажилтан, албан хаагчид шагнал урамшууллын тогтолцооны ил тод, шударга байдал, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, нэмэгдэл, нэмэгдэл хөлс олголт 50.0 % байна.

2. Хүний нөөцийн хөгжих боломж: Ажилтан, албан хаагчдын сэтгэл ханамжтай байдлыг хэмжигдэхүүн тус бүрээр авч үзэхэд:

- Судалгаанд хамрагдсан ажилтан, албан хаагчдын мэргэжлийн болон эрдмийн зэрэг дэв хамгаалах боломж 70%, шинэ санаа, дэвшилтэт арга аргачлал нэвтрүүлэх боломж 68.1 % байна. Сэтгэл ханамжтай байдлыг үзүүлэлтээр нь авч үзвэл мэдлэг, мэргэшлээ дээшлүүлэх, ашиглах боломж, эрдэм шинжилгээ судалгааны ажил хийх, үр дүнг ашиглах боломж, ажлын байран дээр суралцах, хөгжих боломж тус бүр 60.7 % байна.

3. Ажилтан, албан хаагчдын ёс зүй, ур чадвар: Ажилтан, албан хаагчдын сэтгэл ханамжтай байдлыг хэмжигдэхүүн тус бүрээр авч үзэхэд:

- Судалгаанд хамрагдсан ажилтан, албан хаагчдын хувцаслалт, хувийн соёлд 79.7%, эелдэг найрсаг харилцаа, хандлагад 73.0% сэтгэл ханамжтай байна.
- Судалгаанд хамрагдсан ажилтан, албан хаагчдийн нь хамт олны харилцаа, эв нэгдэл 68.3 хувийн, байгууллагын нууцыг хадгалалт 68.5%, бие биенээ хүндэтгэх ур чадвар 68.0% тус бүр сэтгэл ханамжтай байна.
- Судалгаанд хамрагдсан ажилтан, албан хаагчдийн ажилтан, албан хаагчдын ёс зүй 64.8%, ажилтан, албан хаагчдын бусдыг сонсох ур чадварт 62.1 %, мэргэжилтний мэргэжил арга зүйгээр хангах, зөвөлгөө өгөх ур чадварт 63.3% сэтгэл ханамжтай байна.

4. Байгууллагын соёл: Ажилтан, албан хаагчдын сэтгэл ханамжтай байдлыг хэмжигдэхүүн тус бүрээр авч үзэхэд:

- Судалгаанд хамрагдсан ажилтан, албан хаагчдийн угтах, лавлагаа мэдээлэл өгөх үйлчилгээний соёлд 83.1 %, байгууллагын дотоод, гадаад орчны соёл, тохижилт, тав тухад 75.4 % сэтгэл ханамжтай байна.
- Судалгаанд хамрагдсан ажилтан, албан хаагчдийн байгууллагаараа бахархах сэтгэл 71.0 %, байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, стратегийг ажилтан бүр мэддэг, хэрэгжилтийг хангаж ажилладаг 57.4 %, байгууллагын хөгжил, үйл ажиллагааны зар сурталчилгаанд (маркетинг) 57.4 % сэтгэл ханамжтай байна.
- Байгууллагын соёлын бусдаас ялгарах давуу тал, дүр төрхд (имиж) 51.7 % сэтгэл ханамжтай байна.

5. Ажилтан, албан хаагчдын ажлын ур чадвар, хариуцлага: Байгууллагын ажилтан, албан хаагчдын ажлын ур чадвар, хариуцлагын талаарх сэтгэл ханамж: Ажилтан, албан хаагчдын сэтгэл ханамжтай байдлыг хэмжигдэхүүн тус бүрээр авч үзэхэд:

- Судалгаанд хамрагдсан ажилтан, албан хаагчдийн алдаа, эрсдэлгүй ажиллах чадварт 71.3 %, ажлын хариуцлага, шуурхай байдалд 69.4 %, ажлын идэвхи, санаачлагад 69.4 % тус бүр сэтгэл ханамжтай байна.
- Судалгаанд хамрагдсан ажилтан, албан хаагчдийн төлөвлөлтийн ур чадварт 62.3 %, шинэ санаа, санаачилга гаргадаг байдалд 56.5 %, бусдадаа үлгэрлэх, санаачлагад 59.8 % тус бүр сэтгэл ханамжтай байна.

6. Ажлын байрны аюулгүй, дэмжлэгт орчин: Байгууллагын ажлын байрны аюулгүй, дэмжлэгт орчний талаарх сэтгэл ханамж:

Ажилтан, албан хаагчдын сэтгэл ханамжтай байдлыг хэмжигдэхүүн тус бүрээр авч үзэхэд:

- Судалгаанд хамрагдсан ажилтан, албан хаагчдийн ажлын байрны чийрэгжилт, алжаал тайлах нөхцөлд 78.2 % сэтгэл ханамжтай байна.
- Ажлын байрны хангамж, ажиллах нөхцөл, ажлын байрны тав тух, агааржуулалт, тохижилт тус бүрт 74.6 % сэтгэл ханамжтай байна.
- Байгууллагын эрүүл ахуй, халдвар хамгаалалт 64.8 % сэтгэл ханамжтай байна.

ДҮГНЭЛТ:

- Судалгаанд хамрагдсан нийт ажилтан, албан хаагчдийн дийлэнх нь угтах, лавлагаа мэдээлэл өгөх үйлчилгээний соёлд 83.1%, ажилтан албан хаагчдын хувцаслалт, хувийн соёлд 79.7%, ажлын байрны чийрэгжилт, алжаал тайлах нөхцөлд 78.2%, хэлтсийн 73.4%, алдаа эрсдэлгүй ажиллах чадварт 71.3%, удирдлагын удирдах арга барил, манлайлах ур чадварт 61.7% -ийн буюу хамгийн их сэтгэл ханамжтай байна.
- Судалгаанд хамрагдсан нийт ажилтан, албан хаагчдийн дийлэнх нь ажлын байранд дээр суралцах, хөгжих боломжид 60.7%, байгууллагын соёлын бусдаас ялгарах давуу тал, дүр төрхөд (имиж) 51.7%, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, нэмэгдэл, нэмэгдэл хөлс олголтонд 50.0%, шагнал урамшууллын тогтолцооны ил тод, шударга байдалд 47.6%-ийн хамгийн бага сэтгэл ханамжтай байна.

ХҮСНЭГТ 1. СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ (ХУВИАР)

Нэг.Дэмжлэгт удирдлага		Дундаж балл	Дундаж оноо	Бүлгийн дундаж
1.1	Байгууллагын удирдлагын удирдах арга барил, манлайлах ур чадвар	1.8	61.7	59.2
1.2	Албаны удирдлагын удирдах арга барил, манлайлах ур чадвар	1.5	73.4	
1.3	Шийдвэр гаралтанд хамт олны оролцоо	1.8	57.9	
1.4	Шагнал урамшууллын тогтолцооны ил тод, шударга байдал	2.0	47.6	
1.5	Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, нэмэгдэл, нэмэгдэл хөлс олголт	2.0	50.0	
1.6	Мөнгөн бус тусламж, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэлт	1.9	54.2	
1.7	Тасралтгүй суралцагч байгууллага байх тогтолцоо	1.8	60.0	
1.8	Шинэ санаа, санаачилгыг дэмжих, нэвтрүүлэх байдал	1.7	62.9	
1.9	Удирдлагадаа санал бодолоо чөлөөтэй илэрхийлэх боломж	1.8	61.1	
1.10	Ажилчдын эрүүл мэндийн хамгаалах үйл ажиллагаа	1.7	63.6	
Дундаж оноо				
Хоёр.Хүний нөөцийн хөгжих боломж				
2.1	Мэдлэг, мэргэшлээ дээшлүүлэх, ашиглах боломж	1.7	64.3	65.2
2.2	Мэргэжлийн болон эрдмийн зэрэг дэв хамгаалах боломж	1.6	70.0	
2.3	Шинэ санаа, дэвшилтэт арга аргачлал нэвтрүүлэх боломж	1.6	68.1	
2.4	Эрдэм шинжилгээ судалгааны ажил хийх, үр дүнг ашиглах боломж	1.7	63.4	
2.5	Ажлын байранд дээр суралцах, хөгжих боломж	1.8	60.7	
Дундаж оноо				
Гурав.Ажилтан, албан хаагчдын ёс зүй, ур чадвар				
3.1	Ажилтан, албан хаагчдын ёс зүй	1.7	64.8	68.6
3.2	Эелдэг найрсаг харилцаа, хандлага	1.5	73.0	
3.3	Хамт олны харилцаа, эв нэгдэл	1.6	68.3	
3.4	Ажилтан, албан хаагчдын бусдыг сонсох ур чадвар	1.8	62.1	
3.5	Мэргэжилтний мэргэжил арга зүйгээр хангах, зөвөлгөө өгөх ур чадвар	1.7	63.3	
3.6	Бие биенээ хүндэтгэх ур чадвар	1.6	68.0	
3.7	Ажилтан, албан хаагчдын хувцаслалт, хувийн соёл	1.4	79.7	
3.8	Байгууллагын нууцыг хадгалалт	1.6	68.5	
Дундаж оноо				
Дөрөв.Байгууллагын соёл				
4.1	Байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, стратегийг ажилтан бүр мэддэг, хэрэгжилтийг хангаж ажилладаг	1.9	57.4	66.3
4.2	Угтах, лавлагаа мэдээлэл өгөх үйлчилгээний соёл	1.3	83.1	
4.3	Байгууллагын дотоод, гадаад орчны соёл, тохижилт, тав тух	1.5	75.4	
4.4	Байгууллагын хөгжил, үйл ажиллагааны зар сурталчилгаа (маркетинг)	1.9	57.4	
4.5	Байгууллагын соёлын бусдаас ялгарах давуу тал, дүр төрх (имиж)	2.0	51.7	
4.6	Байгууллагаараа бахархах сэтгэл	1.6	71.0	
Дундаж оноо				
Тав.Ажилтан, албан хаагчдын ажлын ур чадвар, хариуцлага				
5.1	Алдаа, эрсдэлгүй ажиллах чадвар	1.6	71.3	64.8
5.2	Ажлын хариуцлага, шуурхай байдал	1.6	69.4	
5.3	Шинэ санаа, санаачилга гаргадаг байдал	1.9	56.5	
5.4	Ажлын идэвхи, санаачилга	1.6	69.4	
5.5	Бусдадаа үлгэрлэх, санаачилга	1.8	59.8	
5.6	Төлөвлөлтийн ур чадвар	1.8	62.3	
Дундаж оноо				
Зургаа.Ажлын байрны аюулгүй, дэмжлэгт орчин				
6.1	Байгууллагын эрүүл ахуй, халдвар хамгаалал	1.7	64.8	70.9
6.2	Ажлын байрны тав тух, агааржуулалт, тохижилт	1.5	74.6	
6.3	Ажлын байрны хангамж, ажиллах нөхцөл	1.5	74.6	
6.4	Ажилчдын хоолны газрын эрүүл ахуй, тохижилт, үйлчилгээ	1.8	62.1	
6.5	Ажлын байрны чийрэгжилт, алжаал тайлах нөхцөл	1.4	78.2	
Дундаж оноо				
Ерөнхий сэтгэл ханамж		65.2		